



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/127/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Л.Баянмөнх
Утас: 99997540
Цахим хаяг: bayanmunkhamina@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Э.АЗЖАРГАЛМАА ТАНАА

2025.02.28 № 60

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад цалингийн зардал өмнөх оноос 171.9 сая төгрөг өссөн нь Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой байна. Мөн авлага 37.6 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжих санхүүжилтийн авлага байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж

4825020207

үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилт, 4 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласнаар Луус сумын засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө 80.2 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	80,025,321.65	117,398,543.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,471,533.49	9,721,457.85
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,471,533.49	9,721,457.85
3121	Төгрөг	1,471,533.49	9,721,457.85
31211	Төрийн сангийн харилцах	935,132.93	9,185,057.29
31218	Ахмадын сангийн харилцах	536,400.56	536,400.56
33	АВЛАГА	8,521,583.00	46,186,586.38
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	8,521,583.00	46,186,586.38
35	БАРАА МАТЕРИАЛ	70,032,205.16	62,026,899.99
351	Түүхий эд материал	38,883,430.55	32,298,852.09
35110	Тусгай зориулалттай материал	4,974,163.60	3,898,139.50
35130	Эм боох материал	33,909,266.95	28,400,712.59
354	Хангамжийн материал	31,148,774.61	29,728,047.90
35410	Бичиг хэргийн материал	54,900.00	112,200.00
35420	Аж ахуйн материал	30,306,986.51	29,098,526.00
35440	Түлш, шатах тослох материал	-	74,400.00
35460	Хүнсний материал	786,888.10	442,921.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	354,094,751.41	488,824,685.30
392	Биет хөрөнгө	343,058,751.41	477,788,685.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	235,974,378.82	355,199,265.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,069,146.57)	(40,835,521.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	56,037,258.88	56,037,258.88
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,260,768.49)	(38,479,139.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,228,834.80	206,444,576.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,935,060.54)	(82,246,263.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,650,816.00	35,800,816.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,567,561.49)	(14,132,308.83)
393	Биет бус хөрөнгө	11,036,000.00	11,036,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,036,000.00	11,036,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	434,120,073.06	606,223,228.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	31,441,924.40	21,989,851.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	31,441,924.40	21,989,851.00
413	Өглөг	31,441,924.40	21,989,851.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	17,113,144.70
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	31,441,924.40	4,876,706.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	402,678,148.66	584,769,778.52
51	Засгийн газрын хувь оролцоо	402,678,148.66	584,769,778.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	356,461,187.26	356,461,187.26
51101	Өмч: - төрийн	356,461,187.26	356,461,187.26
512	Хуримтлагдсан үр дүн	18,372,244.43	200,463,874.29
51210	Өмнөх үеийн үр дүн	145,172,405.13	18,372,244.43
51220	Тайлант үеийн үр дүн	(126,800,160.70)	182,091,629.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,844,716.97	27,844,716.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	434,120,073.06	606,759,629.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	537,611,345.58	1,027,613,463.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,175,497.52	257,746,569.43
120	Нийтлэг татварын бус орлого	69,175,497.52	257,746,569.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,175,497.52	257,746,569.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,305,310.00	44,874,647.00

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	58,870,187.52	212,871,922.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	468,435,848.06	769,866,894.10
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,639,500.00	37,493,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,639,500.00	37,493,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	438,796,348.06	732,373,494.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	438,796,348.06	732,373,494.10
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	663,537,973.20	845,521,833.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	663,537,973.20	845,521,833.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	663,532,945.41	808,118,045.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,257,156.28	510,227,969.87
210101	Үндсэн цалин	237,825,160.33	317,135,938.42
210102	Нэмэгдэл	58,639,418.95	150,148,701.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,294,000.00	4,283,000.00
210104	Урамшуулал	37,498,577.00	38,660,330.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,253,499.44	64,710,081.07
210201	Тэтгэврийн даатгал	29,539,774.15	44,116,507.39
210202	Тэтгэмжийн даатгал	3,475,268.33	5,108,879.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,736,212.84	2,728,994.55
210204	Ажилгүйдлийн даатгал	681,993.80	2,551,140.03
210205	Эрүүл мэндийн даатгал	6,820,250.32	10,204,559.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,765,092.21	32,344,492.31
210301	Гэрэл, цахилгаан	3,805,002.21	3,427,142.31
210302	Түлш, халаалт	23,960,090.00	28,917,350.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,376,383.74	19,538,654.46
210401	Бичиг хэрэг	2,621,200.00	1,801,350.00
210402	Тээвэр, шатахуун	13,683,891.50	10,715,284.36
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	561,400.00	1,042,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,611,102.00	723,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,957,727.00	5,256,220.10
210408	Бараа материал акталсны зардал	1,941,063.24	-
2105	Нормативт зардал	112,023,201.67	91,254,452.35
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	101,840,455.97	81,741,845.85
210502	Хоол, хүнс	10,182,745.70	9,512,606.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,388,430.00	7,579,600.00
210604	Урсгал засвар	17,388,430.00	7,579,600.00
2107	Томилолт, зочны зардал	6,160,000.00	10,094,000.00
210702	Дотоод албан томилолт	6,160,000.00	10,094,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,476,369.00	9,875,243.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,523,000.00	7,068,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,728,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	305,925.00	161,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,700.00	76,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	428,100.00	440,000.00
210807	Газрын төлбөр	102,644.00	101,468.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	224,000.00	245,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,832,813.07	62,493,552.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,017,795.84	1,492,020.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	48,815,017.23	61,001,532.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,027.79	37,403,787.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	35,706,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	35,706,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,027.79	1,697,787.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,027.79	1,697,787.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(125,926,627.62)	182,091,629.86
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	873,533.08	-

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	873,533.08	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(873,533.08)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(126,800,160.70)	182,091,629.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	470,219,575.06	777,076,537.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,305,310.00	44,874,647.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,305,310.00	44,874,647.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,305,310.00	44,874,647.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,305,310.00	44,874,647.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	459,914,265.06	732,201,890.72
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,639,500.00	37,493,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,639,500.00	37,493,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	430,274,765.06	694,708,490.72
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	430,274,765.06	694,708,490.72
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	552,084,730.40	768,826,613.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,084,730.40	768,826,613.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	552,079,702.61	731,422,825.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,257,156.28	500,278,106.24
210101	Үндсэн цалин	237,825,160.33	307,850,759.28
210102	Нэмэгдэл	58,639,418.95	149,572,604.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,294,000.00	4,283,000.00
210104	Урамшуулал	37,498,577.00	38,571,742.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,253,499.44	57,546,800.00
210201	Тэтгэврийн даатгал	29,539,774.15	39,131,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,475,268.33	4,603,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,736,212.84	2,301,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	681,993.80	2,301,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,820,250.32	9,207,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,689,072.21	32,420,512.31
210301	Гэрэл, цахилгаан	3,805,002.21	3,427,142.31
210302	Түлш, халаалт	23,884,070.00	28,993,370.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,965,067.00	18,343,051.76
210401	Бичиг хэрэг	1,297,800.00	1,309,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,108,597.00	12,662,081.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	561,400.00	1,042,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,448,920.00	509,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,548,350.00	2,818,820.00
2105	Нормативт зардал	63,854,118.68	95,572,492.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,769,511.68	86,491,742.36
210502	Хоол, хүнс	8,756,607.00	8,560,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,328,000.00	520,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,158,930.00	7,794,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	809,000.00	-
210604	Урсгал засвар	18,349,930.00	7,794,600.00
2107	Томилолт, зочны зардал	6,160,000.00	8,100,000.00
210702	Дотоод албан томилолт	6,160,000.00	8,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,476,369.00	9,875,243.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,523,000.00	7,068,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,728,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	305,925.00	161,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,700.00	76,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	428,100.00	440,000.00
210807	Газрын төлбөр	102,644.00	101,468.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	224,000.00	245,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,265,490.00	1,492,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,265,490.00	1,492,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,027.79	37,403,787.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	35,706,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	35,706,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,027.79	1,697,787.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,027.79	1,697,787.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(81,865,155.34)	8,249,924.36
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,245,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,245,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	22,245,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,245,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(22,245,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(104,110,155.34)	8,249,924.36
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	105,581,688.83	1,471,533.49
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,471,533.49	9,721,457.85

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	145,172,405.13	529,478,309.36
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	145,172,405.13	529,478,309.36
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-126,800,160.70	-126,800,160.70
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	18,372,244.43	402,678,148.66
5	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	18,372,244.43	402,678,148.66
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	18,372,244.43	402,678,148.66
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	182,091,629.86	182,091,629.86
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	200,463,874.29	584,769,778.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	788,951,600.00	767,128,825.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	788,951,600.00	767,128,825.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	753,245,600.00	731,422,825.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	500,373,600.00	500,278,106.24
210101	Үндсэн цалин	279,874,000.00	307,850,759.28
210102	Нэмэгдэл	132,499,600.00	149,572,604.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,200,000.00	4,283,000.00
210104	Урамшуулал	77,800,000.00	38,571,742.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,546,800.00	57,546,800.00
210201	Тэтгэврийн даатгал	39,131,800.00	39,131,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,603,700.00	4,603,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,301,900.00	2,301,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,301,900.00	2,301,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,207,500.00	9,207,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,993,400.00	32,420,512.31
210301	Гэрэл, цахилгаан	4,000,000.00	3,427,142.31

210302	Түлш, халаалт	28,993,400.00	28,993,370.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	22,164,400.00	18,343,051.76
210401	Бичиг хэрэг	1,407,500.00	1,309,700.00
210402	Тээвэр, шатахуун	16,103,700.00	12,662,081.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,048,500.00	1,042,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	689,700.00	509,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,915,000.00	2,818,820.00
2105	Нормативт зардал	100,499,000.00	95,572,492.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,297,400.00	86,491,742.36
210502	Хоол, хүнс	10,051,600.00	8,560,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,150,000.00	520,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	7,794,600.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,794,600.00
2107	Томилолт, зочны зардал	8,100,000.00	8,100,000.00
210702	Дотоод албан томилолт	8,100,000.00	8,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,068,700.00	9,875,243.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,200,500.00	7,068,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,728,000.00	1,728,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,000.00	161,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	76,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	441,400.00	440,000.00
210807	Газрын төлбөр	102,000.00	101,468.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	291,800.00	245,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,499,700.00	1,492,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,499,700.00	1,492,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,706,000.00	35,706,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,706,000.00	35,706,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,706,000.00	35,706,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	788,951,600.00	775,378,750.03
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,493,400.00	35,795,612.31
122005	Орон нутгийн төсвөөс	37,493,400.00	35,795,612.31
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/	44,874,600.00	44,874,647.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	705,648,500.00	694,708,490.72
122001	Хандив тусламж /дотоод/	705,648,500.00	694,708,490.72
1200043	Оны эхний үлдэгдэлээс санхүүжих	935,100.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	935,132.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,185,057.29

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,454.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 9,055.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 398.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт хүргүүлжээ.

Залруулсан алдаа:

Бараа үйлчилгээний бусад зардлыг 9,055.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 398.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, нөхөн төлүүлэх акт тогтоолоо.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

Автомашины шатахууны зарцуулалтын нормыг хэтрүүлэн 398.4 мянган төгрөгийн шатахуун илүү тооцож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т /, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" мөн хуулийн 20.2.4-д: "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг, мөн нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			